



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 09 өдөр

Дугаар А/10

Амардалай

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.4 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.10, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баяр наадмын хандивын хөрөнгөөр ажил гүйцэтгэх гэрээний дагуу хийгдсэн хөрөнгийг хүлээн авах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Баярмаа (Санхүү албаны дарга)

Гишүүд: Б.Баттогтох (ХААТ-ийн мэргэжилтэн)

Б.Баярмаа (ЗДТГ-ын нярав)

Г.Дэжидсүрэн (ЗДТГ-ын нягтлан бодогч)

Б.Сармандах (ЖДҮ хариуцсан мэргэжилтэн)

2. Уг хөрөнгийн чанар байдал, стандарт, зураг төсвийг үзэж тулган хүлээн авах, тэмдэглэл хөтлөх, гүйцэтгэлийн тайланг гүйцэтгэгч талаар гаргуулан шаардлага хангаж буй эсэхэд хяналт тавьж, шаардлагад нийцсэн бараа хүлээн авах, холбогдох акт баримтыг журмын дагуу үйлдэж, бүрдүүлэхийг ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА:  С.НАРАНТУНГАЛАГ

